

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 07 ДУГААР ХУРАЛ**

2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 11 цаг 20 минутад эхэлж, мөн өдрийн 13 цаг 40 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын танхимд хийж, нийт 02 цаг 20 минутад хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ, тайлан судалгаа \2009-2020 он\	1.Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ, тайлан судалгаа \2009-2020 он\-г хэлэлцэх явцад гарсан саналыг тусган дахин баяжилт хийж, иргэдэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболдод үүрэг болгов.
2	Авто машин шилжүүлэх тухай	1.2011 онд үйлдвэрлэгдсэн 2019 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн Kia new parkway Grandbird маркийн 1258 ХОА улсын дугаартай 45 хүний суудалтай автобусыг аймгийн Хөгжимт драмын театрын балансад 2.2014 онд үйлдвэрлэгдсэн 2019 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн Hyundai Country маркийн 3325ХОА улсын дугаартай 24 хүний суудалтай автобусыг аймгийн Биеийн тамир, спортын газрын балансад 3.2011 онд үйлдвэрлэгдсэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын ажлуудын техник хяналтын зардлаас худалдан авсан Land Cruiser Prado маркийн 1966 ХОУ улсын дугаартай Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын балансад бүртгэлтэй суудлын автомашиныг аймгийн Засаг даргын Тамгын газрын балансад тус тус зохих журмын дагуу шийдвэр гаргуулж балансаас балансад шилжүүлэх талаар аймгийн Орон нутгийн өмчийн газарт албан бичиг хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболдод үүрэг болгов.
3	Засаг даргын нөөц хөрөнгийн хүлээгдэж буй гүйцэтгэлийн тухай	1.Засаг даргын нөөц хөрөнгийн хүлээгдэж буй 16.071.245 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

		Ч.Багдалд, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболд нарт тус тус үүрэг болгов.
--	--	---

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР